

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа газрыг тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх арга, тактикийг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах “Гэмт хэргийн хяналтын цогц систем” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

“ГЭМТ ХЭРГИЙН ХЯНАЛТЫН ЦОГЦ СИСТЕМ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Гэмт хэргийн хяналтын цогц системийг ашиглан гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа газрыг тодорхойлон гэмт хэрэгтэй тэмцэх оновчтой арга, тактикийг төлөвлөн хэрэгжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулахад оршино.				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх, мэдээлэл дамжуулах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хяналтын системийг ашигласнаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө сайжирч цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ.				
Үйл ажиллагааны чиглэл		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд техник технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгоно.				
д/д	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Гэмт хэргийн хяналтын цогц систем дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд:						
1	Нийслэл хотод үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхойлоход Агстар газарзүйн программ, ASAP, TPS мэдээллийг ашиглах,	Нэгдсэн төвд суурилуулан техник, тоног төхөөрөмжийг ашиглан Нийслэл хотод үйлдэгдэж буй гэмт хэрэг, захиргааны зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа ашиглана.	Гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж ажилласан байдал	НЦГ	НМТГ	2018
2	system.police.gov сайтад мэдээлэл байршуулах,	Нэгдсэн төвд ашиглагдах тоног төхөөрөмжийг Агстар газарзүйн программын лиценз болон дагалдах нэмэлт хэрэгслүүдээр хангана.	Лиценз болон дагалдах нэмэлт хэрэгслүүдээр хангагдсан байдал			2018

3	солилцох, мэдээлэл, холбоо, технологийн үйлчилгээг шуурхай авах, холбогдох нөхцөлийг бүрдүүлэх.	Цагдаагийн алба хаагчид ASAP, TPS мэдээллийн сангаас цаг хугацаа алдалгүй сэжигтэн этгээд, тээврийн хэрэгсэл, жолоочийн бүртгэл мэдээлэл хайх, system.police.gov сайтад мэдээлэл байршуулах, бусад алба хаагчидтай мэдээлэл солилцох, мэдээлэл, холбоо, технологийн үйлчилгээг шуурхай авах, холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.	Нэгдсэн сүлжээгээр дамжуулан авах мэдээлэл, холбоо, технологийн үйлчилгээг бүрдүүлсэн байдал		ЦЕГ-ын Мэдээллийн технологийн төв	2018	
Гэмт хэргийн хяналтын цогц систем дэд хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд:							
1	Гэмт хэргийн болон өргөдөл, гомдлын цахим зураглал ашиглан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтын байдалд дүн шинжилгээ хийж эргүүлийн нэгдсэн байршилтыг урьдчилан тодорхойлж, цахим эргүүл ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэн урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн бодлого, шийдвэрээр хэрэгжүүлэх.	Нийслэл хотод үйлдэгдэж буй гэмт хэргийн өнгө, өсөлт, бууралт, хэрэг үйлдэгдсэн газрыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулна.	Урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан байдал.	НЦГ	-	2018	
2		Гэмт хэргийн болон өргөдөл, гомдлын цахим зураглал ашиглан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтын байдалд дүн шинжилгээ хийж, эргүүлийн нэгдсэн байршилтыг урьдчилан тодорхойлон, эргүүлийн чиглэлийг оновчтой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	Эргүүлийн чиглэлийг оновчтой ажиллуулсан байдал	НЦГ	-		
3		Нэгдсэн төвөөс гаргасан судалгаанд үндэслэн Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг тооцно.	Нэгдсэн бодлого гаргаж, хэрэгжүүлсэн байдал				
4		Гэмт хэргийн цахим зураглал ашиглан бодит статистик мэдээлэл боловсруулан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эмзэг цэгүүдийг телекамерын хяналтад авах ажлыг хэрэгжүүлнэ.	Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авсан байдал	НЦГ		ЦЕГ-ын Мэдээллийн технологийн төв, НМТГ	2018-2020
5		Нийслэл хотод төсвийн болон орон нутгийн хөрөнгө, гадаад улсын зээл, тусламжаар тавигдсан хяналтын камеруудыг нэгтгэх программ хангамжийг ашиглан цахим эргүүл ажиллуулж, үр дүнг тооцно.	Цахим эргүүл ажиллуулж, үр дүнг тооцсон байдал				

Гэмт хэргийн хяналтын цогц систем дэд хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд:

1	Цагдаагийн байгууллагын нэгдсэн санг өргөтгөж, мэдээлэл дамжуулах цогц программ хангамжийн хүрээнд мэдээлэл дамжуулах ухаалаг төхөөрөмж /таблет, бэлэн бус торгуулийн төхөөрөмж/-өөр авто эргүүл, цагдаагийн дэд хэсэг, жижүүрийн шуурхай алба, эрүүлжүүлэх байр, хэсгийн байцаагч нарыг хангаж үйл ажиллагаандаа ашиглах.	Ухаалаг цагдаа төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлнэ.	Тооцоо судалгаа гаргаж шийдвэрлүүлсэн байдал	НЦГ	НМТГ	2018
2		Нийслэлийн засаг, захиргааны анхан шатны нэгж болох хороодын дэд бүтцийг ашиглан 152 хэсгийн байцаагчийн байр, 24 дэд хэсгийн байрыг шилэн кабельд холбох ажлыг хэрэгжүүлнэ.	Шилэн кабельд холбогдсон хорооны цагдаагийн байр, цагдаагийн дэд хэсгийн тоо		ЦЕГ-ын Мэдээллийн технологийн төв	2018-2018
3		Цагдаагийн байгууллагын нэгдсэн санг өргөтгөж мэдээлэл дамжуулах цогц программ хангамж боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглана.	Программ боловсруулж, үйл ажиллагаандаа ашигласан байдал	НЦГ	ЦЕГ-ын Мэдээллийн технологийн төв, НМТГ	2018
4		Мэдээлэл дамжуулах цогц программ хангамжийн хүрээнд мэдээлэл дамжуулах ухаалаг төхөөрөмж /таблет, бэлэн бус торгуулийн төхөөрөмж/-өөр авто эргүүл, цагдаагийн дэд хэсэг, жижүүрийн шуурхай алба, эрүүлжүүлэх байр, хэсгийн байцаагч нарыг хангаж, үйл ажиллагаандаа ашиглана.	Ухаалаг төхөөрөмжөөр хангасан байдал	НЦГ		2018-2020
5		Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний нэгдсэн хяналтын систем боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглах.	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний нэгдсэн хяналтын систем боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглана.	Нэгдсэн хяналтын систем боловсруулж, үйл ажиллагаандаа ашигласан байдал	ЦЕГ-ын Мэдээллийн технологийн төв	2018-2020

Гэмт хэргийн хяналтын цогц систем дэд хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

1	Гадаад улс орнуудын нэгдсэн төв, гэмт хэргийн цахим зураглал ашиглан гэмт хэрэгтэй тэмцэх ажлын тэргүүн туршлагыг судалж, алба хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах.	Гадаад улс орнуудын нэгдсэн төв, гэмт хэргийн цахим зураглал ашиглан гэмт хэрэгтэй тэмцэх ажилтай танилцаж, тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.	Тэргүүн туршлагыг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдал	НЦГ	ЦЕГ	2018-2020
2	Албан хаагчдыг гэмт хэргийн цогц системийг ашиглах талаар мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцно.	Албан хаагчдыг гэмт хэргийн цогц системийг ашиглах талаар мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцно.	Сургалтыг зохион байгуулсан байдал		ЦЕГ-ын сургалтын төв	2018-2020

---000---